




Улаанбаатар хот

170 70 0118

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 04 дугаар сарын 18-ний өдрийн
1/16 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт



“ЧАНАРТАЙ СЭРГЭЭН ЗАСАЛТ - АМЬДРАЛЫН ЧАНАР” ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ

Үндэслэл:

МУ-ын “Эрүүл мэндийн тухай” хуулийн 13.4-т заасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэргүүлэх 4 төрлийн нэг нь Сэргээн засах тусламж үйлчилгээ байдаг.

Сэргээн засах тусламж үйлчилгээ нь хүний үйл ажиллагааны чадвар, түвшинг үнэлж, оношилж, эмчилж, чадвар алдагдлаас урьдчилан сэргийлдэг онцлогтой анагаах ухааны бие даасан салбар юм.

Сүүлийн жилүүдэд хүн амын дундаж насжилт уртассаг, халдварт бус өвчлөл нэмэгдэхийн хирээр саа саажилттай болон тулгуур эрхтэн тогтолцооны эмгэгтэй өвчтний тоо өссөөр байна. Эдгээр өвчтний өдөр тутмын хөдөлгөөний, танин мэдэхүйн үйл ажиллагаа алдагдаж, амьдралын чанар буурснаар хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байдаг. Иймд бие-сэтгэц-нийгмийн загвараар хүний чадвар алдагдлыг оношлон, эмчлэж бусдын хараат бус, бие даасан болгох зорилгоор сэргээн засах тусламж, үйлчилгээг чанар, хүртээмжтэй үзүүлэх шаардлага хэрэгцээ байна.

Төрөөс баримтлах эрүүл мэндийн бодлогын 2.4.2.9.-д сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, олон улсын жишгээр хөгжүүлнэ гэж тусгасан байдаг. ХУЭМТөв нь сэргээн засах тусламж үйлчилгээг олон улсын жишигт ойртуулах зорилгоор МУ-ын Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.21-д заасны дагуу олон төрлийн мэргэжилтэн бүхий баг ажиллаж, эмчилгээндээ орчин үеийн үнэлгээ, эмчилгээний аргуудыг ашиглаж байна.

Зорилго:

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагын төлөөлөгчид, иргэдэд ХУЭМТ-ийн “Сэргээн засах” кабинетийн үйл ажиллагааг танилцуулах, сурталчилах, харилцан туршлага солилцоход оршино.

Зохион байгуулах газар: ХУД-ийн Эрүүл Мэндийн Төвийн сэргээн засах кабинет

Хугацаа: 2017 оны 4-р сарын 27-ны өдөр 11.30 цагт

Зохион байгуулагч: Хан- уул Эрүүл мэндийн төв

Хамтран зохион байгуулагч: Нийслэлийн эрүүл мэндийн газар

Хамрах хүрээ:

- ХУЭМТ-ийн удирдлагууд, сэргээн засах эмчилгээний баг
- НЭМГ-ийн мэргэжилтэн н.Энхжаргал, н. Цэнджав
- ХУД-ийн ЗДТГ-ын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
- НЭМГ-ын харьяа байгууллагуудын чанарын болон сэргээн засах эмч мэргэжилтнүүд
- Сэргээн засах мэргэжлийн нийгэмлэгүүдийн төлөөлөл
- ХУД-ийн ӨЭМТ-ийн дарга нар
- Иргэд үйлчлүүлэгчид


Үйл ажиллагаа:

1. Хан-уул эрүүл мэндийн төвийн хөдөлгөөн засал болон сэргээн засах тусламж үйлчилгээний кабинетуудын танилцуулга хийх
2. Төвд ашиглаж буй аппарат, тоног төхөөрөмжийг танилцуулах
3. Хөдөлгөөн засал эмчилгээний шинэлэг санаа, туршлага танилцуулах
4. Мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах
5. Туршлага солилцох

Гарах үр дүн:

1. Эрүүл мэндийн салбаруудад “Сэргээн засах кабинет”-ын үйл ажиллагааг таниулснаар бусад дүүргийн эрүүл мэндийн газруудын тусламж үйлчилгээ хөгжихөд хувь нэмэр оруулна.
2. ЭМЯ болон НЭМГ-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамрагдах боломж нээгдэнэ.
- 3. Эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг сайжруулна

Хан-уул Эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 04 дугаар сарын 18-ний өдрийн
А/16 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт



“ЧАНАРТАЙ СЭРГЭЭН ЗАСАЛТ - АМЬДРАЛЫН ЧАНАР”
ӨДӨРЛӨГИЙН ХӨТӨЛБӨР

Хэзээ: 2017 оны 04 сарын 27 өдрийн 11³⁰-14³⁰ цагт

Хаана: ХУЭМТөвийн сургалт арга зүйн кабинет, сэргээн засах кабинет

11.30 – 11.40

Төлөөлөгчид цуглана, бүртгэл хийх

11.40 – 11.45

Нээлтийн ажиллагаа: ХУЭМТ-ийн дарга Э. Бодьцэцэг нээж үг хэлнэ. /5 минут/

11.45 – 11.50

НЭМГ-ын төлөөлөгч үг хэлэх

11.55 – 12.15

Сэргээн засах тусламж үйлчилгээний танилцуулга, Яармаг салбарын сэргээн засах кабинетийн танилцуулга /видео хэлбэрээр/ - Сэргээн засах эмчилгээний эмч Б.Энхтуяа, Б.Мэндбилэг

12.15 – 12.30

Сэргээн засах эмчилгээний дэлхийн чиг хандлага – Зочин илтгэл

12.30 – 13.00

ХУЭМТ-ийн Сэргээн засал эмчилгээний онцлог, хийгдэж буй удалгаанууд, харвалтын багийн үйл ажиллагааны танилцуулга, өвчний тохиолдол танилцуулах - Сэргээн засах эмчилгээний эмч Ж.Соёлмаа

13.00– 13.15

Хөнгөн үдийн цай

13.15 – 13.40

Сэргээн засал кабинетуудын үйл ажиллагааг танилцуулах – үзүүлэн материалтай танилцах /Сэргээн засах эмчилгээний багийн боловсруулсан удирдамж, гарын авлага г.м/

13.40 – 14.00

Санал сэтгэгдлээ солилцох

14.00– 14.05

Хаалтын ажиллагааг хааж Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Д. Сүнжидмаа үг хэлнэ.

14.05 – 14.15

Дурсгалын зураг авах